



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 сарын 11 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11¹.1 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 11¹.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалтын, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР